

**Хөдөлгөөнт банкны үйлчилгээний
журам батлах тухай**

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журмыг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), хөдөлгөөнт банкны үйлчилгээ эрхлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т тус тус даалгасугай.
- 4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-204 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАЯРТСАЙХАН

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь хөдөлгөөнт банкны үйлчилгээ, тус үйлчилгээтэй холбогдуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэгч банкны бүрэн эрх, хөдөлгөөнт банкны үйлчилгээний нууцлал, аюулгүй байдал, найдвартай, тасралтгүй байдлыг хангах, хяналт тавих, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэх харилцаанд Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, энэ журам болон Монголбанкнаас баталсан холбогдох бодлого, журмыг удирдлага болгоно.
- 1.3 Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, тус үйлчилгээтэй холбогдуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэхэд дараах зарчмыг баримтална:
 - 1.3.1 Аливаа мэдээлэл алдагдах, гэмтэх, устаж алга болохоос хамгаалсан буюу “Аюулгүй байдал”-ыг хангасан байх;
 - 1.3.2 Санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг “Гүйлгээ”-гэж тодорхойлох;
 - 1.3.3 Тухайн өдрийн 00:00 цагаас дараагийн өдрийн 00:00 цаг хүртэлх хугацааг (хуульд заасан нийтээр амрах баярын болон амралтын өдрийг оруулна) “Гүйлгээ дамжуулах өдөр” гэж тодорхойлох;
 - 1.3.4 Урьдчилан төлөвлөгдөөгүй хүчин зүйлийн улмаас хөдөлгөөнт банкны үйлчилгээ 2 минутаас дээш хугацаагаар хэсэгчлэн болон бүрэн зогсохыг “Гэнэтийн саатал” гэж тооцох;
 - 1.3.5 Үйлчилгээ үзүүлэгч банктай байгуулсан гэрээний үндсэн дээр хөдөлгөөнт банкны үйлчилгээ ашиглан өөрийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг борлуулж буй хувь хүн, хуулийн этгээдийг “Гэрээт хамтрагч” гэж тодорхойлох;
 - 1.3.6 Хэрэглэгчээс олгосон эрхийн хүрээнд хэрэглэгчийн данснаас зарцуулалт хийх этгээдийг “Дэд хэрэглэгч” гэж тодорхойлох;
 - 1.3.7 Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгө болон нууцад хамаарах мэдээллийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд итгэл эвдэх буюу хуурч мэхлэх аргаар өөрийн эзэмшилд оруулахыг “Залилан мэхлэх гүйлгээ” гэж тооцох;
 - 1.3.8 Хэрэглэгч интернэт протокол ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авахыг “Интернэт хандалт” гэж тодорхойлох;
 - 1.3.9 Хэрэглэгч USSD, SMS зэрэг үүрэн холбооны технологи ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авахыг “мобайл хандалт” гэж тодорхойлох;
 - 1.3.10 Мэдээллийг криптографийн аргаар нууцалж хадгалах, дамжуулах, зөвшөөрөлгүй этгээд унших буюу ашиглах боломжгүй болгохыг “Нууцлал” гэж тодорхойлох;

- 1.3.11 “Үйлчилгээ үзүүлэгч банкны үзүүлж буй мөнгөн дүнгээр үл илэрхийлэгдэх хөдөлгөөнт банкны үйлчилгээгээр дамжуулж буй гүйлгээг “Санхүүгийн бус гүйлгээ” гэж тодорхойлох;
 - 1.3.12 Үйлчилгээ үзүүлэгч банкны үзүүлж буй мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хөдөлгөөнт банкны үйлчилгээгээр дамжуулж буй гүйлгээг “Санхүүгийн гүйлгээ” гэж тодорхойлох;
 - 1.3.13 Оролцогч нь шинэчлэл, засвар, үйлчилгээ хийх зорилгоор урьдчилан төлөвлөсний дагуу хөдөлгөөнт банкны үйлчилгээний нэгдсэн сүлжээг түр хугацаагаар хэсэгчлэн болон бүрэн зогсоохыг “Төлөвлөгөөт тасралт” гэж тооцох;
 - 1.3.14 Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлж байгаа банкныг “Үйлчилгээ үзүүлэгч банк” гэж тодорхойлох;
 - 1.3.15 Үйлчилгээ үзүүлэгч банкинд хэрэглэгчийн цахим мэдээг дамжуулах үүрэг бүхий үүрэн холбоо, интернэт, мэдээллийн технологи, холболт зэрэг үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагыг “Харилцаа холбооны байгууллага” гэж тодорхойлох;
 - 1.3.16 Оролцогч, гэрээт төлөөлөгч, гэрээт хамтрагч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, харилцаа холбооны байгууллага, тэдгээрийн хөдөлгөөнт банкны үйлчилгээнд ашиглаж буй техник технологи, програм хангамж, сүлжээ болон холбогдох бодлого, журам, заавар, гэрээний нэгдлийг “Хөдөлгөөнт банкны үйлчилгээний нэгдсэн сүлжээ” гэж тодорхойлох;
 - 1.3.17 Мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж ашиглаж, банкин дээр очилгүйгээр өөрийн данс руу хандаж, төлбөр гүйцэтгэх, банкны бусад үйлчилгээг авах боломжийг хэрэглэгчид олгож буй банкны үйлчилгээг “Хөдөлгөөнт банкны үйлчилгээ” гэж тодорхойлох;
 - 1.3.18 Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгө болон нууцад хамаарах мэдээллийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд санаатайгаар, шунахайн зорилгоор, нууцаар өөрийн эзэмшилд оруулахыг “Хулгайн гүйлгээ” гэж тодорхойлох;
 - 1.3.19 Гүйлгээний цахим бүтцийг “Цахим мэдээ” гэж тодорхойлох.
- 1.4 Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн гүйлгээг тухай бүрт нь дамжуулж, тасралтгүй үйлчилгээ үзүүлэх буюу найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 1.5 Төлбөрийн картаар гүйлгээ хийх үйл ажиллагааг Монголбанкны холбогдох журмаар зохицуулна.

ХОЁР.ОРОЛЦОГЧИЙН БҮРЭН ЭРХ

- 2.1 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.7-д тодорхойлсон оролцогч нь үйлчилгээ үзүүлэгч банк байх бөгөөд уг банк нь энэ журмаар тавигдах шаардлагыг хангасны үндсэн дээр журмын нэгдүгээр хавсралтад заасан болон бусад хөдөлгөөнт банкны үйлчилгээг үзүүлнэ.
- 2.2 Үйлчилгээ үзүүлэгч банк нь дараах үүрэгтэй:
 - 2.2.1. Хэрэглэгчтэй үйлчилгээний нөхцөлийг тодорхой заасан гэрээ байгуулах;
 - 2.2.2. Хэрэглэгчийг үйлчилгээний гарын авлагаар хангах;
 - 2.2.3. Хэрэглэгчийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй байх;
 - 2.2.4. Хөдөлгөөнт банкны үйлчилгээний нууцлал, аюулгүй байдлыг үйлчилгээ үзүүлэгч банк хангаагүйгээс учирсан хохирлыг хариуцах;

- 2.2.5. Үйлчилгээ үзүүлэгч банкинд хөдөлгөөнт банкны үйлчилгээний техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээ, програм хангамжийг ашиглуулж буй хуулийн этгээд буюу Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.17-д тодорхойлсон төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон харилцаа холбооны байгууллагатай хөдөлгөөнт банкны үйлчилгээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах талаар гэрээ байгуулан ажиллах;
 - 2.2.6. Гэрээт төлөөлөгч, гэрээт хамтрагчтай хуанлийн 15 хоногийн дотор тооцоо нийлж тохируулах;
 - 2.2.7. Өөрийн гэрээт төлөөлөгчийн хөдөлгөөнт банкны үйлчилгээтэй холбоотой санхүүгийн хариуцлагыг бүрэн хүлээх;
 - 2.2.8. Цахим мэдээ, тайлангийн үнэн, зөвийг хариуцах;
 - 2.2.9. Хэрэглэгчид гүйлгээ хийгдсэн эсэх мэдээллийг үнэ төлбөргүй мэдэгдэх сувагтай байх;
 - 2.2.10. Хэрэглэгчийн нэвтрэх эрх, дансны мэдээлэл цахим халдлагад өртөж, алдагдсан тохиолдолд хэрэглэгчид нэн даруй мэдэгдэж, авч буй арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэх;
 - 2.2.11. Хөдөлгөөнт банкны үйлчилгээний тайлан, мэдээг энэ журмын 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хавсралтад заасны дагуу улирал тутам гаргаж, дараа сарын 25-ны өдрийн дотор Монголбанкинд ирүүлэх.
- 2.3 Үйлчилгээ үзүүлэгч банк нь хэрэглэгчтэй байгуулах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:
- 2.3.1. Үйлчилгээний төрөл, нэгж гүйлгээний болон нэг өдөрт хийх гүйлгээний дүн, давтамжийн хязгаар;
 - 2.3.2. Үйлчилгээ үзүүлэгч банк болон хэрэглэгчийн эрх, үүрэг, хариуцлага;
 - 2.3.3. Хөдөлгөөнт банкны үйлчилгээний шимтгэл, хураамж;
 - 2.3.4. Гомдол, маргааныг хүлээн авах, шийдвэрлэх зарчим, хугацаа;
 - 2.3.5. Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч банк нь хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө энэ талаар хэрэглэгчид мэдэгдэх, заасан хугацаанд хэрэглэгч гэрээнээс татгалзаагүй тохиолдолд өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгох тухай;
 - 2.3.6. Хэрэглэгч нь дараах нөхцөл үүссэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч банкинд нэн даруй хандах тухай:
 - а. Хөдөлгөөнт банкны үйлчилгээнд нэвтрэх эрхээ бусдад алдсан;
 - б. Нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан интернэт эсхүл мобайл хандалт хийснийг мэдсэн.
- 2.4 Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв (Цашид “ҮЦГТ” гэх) нь хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэх харилцаанд дараах үүрэгтэй оролцоно:
- 2.4.1. Хэрэглэгчийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй байх;
 - 2.4.2. Хөдөлгөөнт банкны үйлчилгээний нэгдсэн сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангах;
 - 2.4.3. Цахим мэдээ, тайлангийн үнэн, зөвийг хариуцах.

ГУРАВ.ОРОЛЦОГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

- 3.1 Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ үзүүлэгч банк нь дараах шаардлагыг хангасан байна:

- 3.1.1 Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- 3.1.2 Үр дүнгийн төлбөр тооцоог Монголбанкн дахь харилцах дансаар гүйцэтгэх;
- 3.1.3 Хөдөлгөөнт банкны үйлчилгээгээр мэргэшсэн ажилтантай байх;
- 3.1.4 Энэхүү журмын 7, 8-д заасан шаардлагыг хангах;
- 3.1.5 Хэрэглэгчийн гомдол, маргааныг хүлээн авах, шийдвэрлэх зарчим, хугацаа зэргийг тодорхой тусгасан журамтай байх;
- 3.1.6 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх зэргийг тодорхой тусгасан журам, заавартай байх;
- 3.1.7 Энэхүү журам болон холбогдох эрх бүхий байгууллагын шаардлагад нийцсэн дараах нөхцөлийг тусгасан дүрэм, журамтай байх:
 - а. Төлбөр тооцоо гүйцэтгэх, тооцоолол хийх;
 - б. Хэрэглэгчийг таних;
 - в. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
 - г. Найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах;
 - д. Нууцлал, аюулгүй байдлыг хангах;
 - е. Хэрэглэгчийг хамгаалах, гомдол, маргаан шийдвэрлэх;
 - ж. Бусад.

ДӨРӨВ.ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХТЭЙ ХАМААРАЛ БҮХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА

- 4.1 Хөдөлгөөнт банкны үйлчилгээтэй холбогдуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь үйлчилгээ үзүүлэгч банкт хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.17-д заасан техник технологи, мэргэжлийн боловсон хүчний болон Монголбанкнаас тодорхойлох бусад дэмжлэг үзүүлнэ.
- 4.2 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1.2-д заасан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Монголбанкнаас авсан байна.
- 4.3 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь дараахь шаардлагыг хангасан байна:
 - 4.3.1 Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг өөр дээрээ байршуулахгүй, татан төвлөрүүлэхгүй, эзэмшихгүй байх;
 - 4.3.2 Энэ журмын 4.1-д заасан дэмжлэг үзүүлэх чадвартай мэргэжлийн боловсон хүчинтэй байх;
 - 4.3.3 Энэ журмын 4.1-д заасан дэмжлэгийг тасралтгүй, найдвартай явуулахуйц дэд бүтэц, програм хангамжтай байх;
 - 4.3.4 Мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангасан байх;
 - 4.3.5 Банк хоорондын гүйлгээг ҮЦГТ-өөр дамжуулж гүйцэтгэх боломжтой байх;
 - 4.3.6 Банк хоорондын гүйлгээ дамжуулах үйл ажиллагаанд оролцох бол ҮЦГТ-тэй хамтарсан туршилт хийж, техникийн дүгнэлт гаргуулсан байх;
 - 4.3.7 Оролцогч, хэрэглэгчийн гаргасан санал, хүсэлт, гомдол, маргааныг хянах, түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоотой байх.
- 4.4 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь дараахь үүрэгтэй:
 - 4.4.1 Банкт хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;

- 4.4.2 Журмын 4.1-д заасан дэмжлэгийг тасралтгүй гүйцэтгэх;
- 4.4.3 Банкны харилцагчийн хувийн нууцад хамаарах болон гүйлгээний мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй, хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй байх.
- 4.5 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь банктай байгуулсан гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:
 - 4.5.1 Талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
 - 4.5.2 Үйлчилгээний шимтгэл, түүнийг хуваарилах зарчим;
 - 4.5.3 Төлбөрийг бодит цагийн горимоор дамжуулах тухай;
 - 4.5.4 Гомдол, маргаан шийдвэрлэх зарчим;
 - 4.5.5 Үйлчилгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангах тухай;
 - 4.5.6 Үйлчилгээний тасралтгүй, найдвартай байдлыг бүрэн хангах тухай.

ТАВ.ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

- 5.1 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1-т заасан, энэ журмын 4.3-т заасан шаардлагыг хангасныг нотлох болон дараах баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ.
 - 5.1.1 Энэ журмын 4.5-д заасан нөхцөлийг тусгасан банктай байгуулах гэрээний батлагдсан загвар;
 - 5.1.2 Ирүүлсэн баримт бичиг нь энэ журмын 4.3-т заасан шаардлагыг хэрхэн хангасан тухай тайлбар.
- 5.2 Монголбанк энэ журмын 5.1-т заасан баримт бичгийг хянаж, бүрдүүлбэр дутуу, нэмэлт материал шаардлагатай тохиолдолд 60 (жар) хоногийн дотор хүсэлт гаргагчид албан бичгээр эсвэл цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 5.3 Хүсэлт гаргагч нь Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу зөвшөөрлийн баримт бичиг хүлээж авах хураамжийг төлөх бөгөөд зөвшөөрлийн баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах, нэмэлт материал ирүүлэх тохиолдолд зөвшөөрлийн материал хүлээж авах хураамжийг дахин төлөхгүй.
- 5.4 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 5.5 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шийдвэр гарсан тохиолдолд хүсэлт гаргагч нь Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан холбогдох зөвшөөрлийн хураамжийг төлнө.
- 5.6 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд зааж, энэ журамд тодорхойлсон шаардлагыг хангасан, зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл байхгүй бол хүсэлт гаргагчид зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар олгоно.
- 5.7 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан хугацаагаар олгоно.

- 5.8 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь өөрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх бол энэ журмын 5.7-т заасан зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос 180 хоногийн өмнө зөвшөөрөл сунгах хүсэлт гаргана.
- 5.9 Зөвшөөрөл сунгах хүсэлтийг энэ журмын 5.1-5.6-т заасны дагуу шийдвэрлэж, зөвшөөрлийг хугацаагүй олгоно.
- 5.10 Монголбанк дараах үндэслэлээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзана.
- 5.10.1 Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15.3-т заасан хугацаа хэтэрсэн;
- 5.10.2 Үндэсний төлбөрийн систем, эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж Монголбанк үзсэн.
- 5.11 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан тухай Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15.2-г үндэслэн хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.12 Зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан хариу авсан этгээд дахин хүсэлт гаргах тохиолдолд энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн хүсэлт гаргана.
- 5.13 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.1-т заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:
- 5.14 Монголбанкны хяналт, шалгалтаар энэ журмын 5.13-т заасан үндэслэл арилсан нь тогтоогдвол шалгалтын дүгнэлтийг үндэслэн Монголбанкны шийдвэрээр холбогдох зөвшөөрлийг сэргээнэ.
- 5.15 Төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээхдээ түдгэлзүүлсэн хугацааг нөхөн тооцохгүй.
- 5.16 Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.2-т заасан үндэслэлээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 5.17 Хүчингүй болсон зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг дахин эрхлэх тухай хүсэлтийг Монголбанк тухайн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын хугацаанд хүлээн авахгүй бөгөөд хүсэлт гаргагч нь тогтоосон хугацааны дараа энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн хүсэлт гаргаж болно.
- 5.18 Энэ журмын 5.13 болон 5.16-д заасан үндэслэлээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авахтай холбогдон гарсан зардлыг тухайн хуулийн этгээд хариуцна.

ЗУРГАА.ОРОЛЦОГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 6.1 Оролцогч нь дараах болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, бууруулах арга хэмжээг авна:
- 6.1.1 Зээлийн эрсдэл буюу санхүүгийн үүргээ тогтоосон хугацаанд нь төдийгүй хойшид биелүүлэх боломжгүй болсноос үүсэх эрсдэл;

- 6.1.2 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл буюу санхүүгийн үүргээ тогтоосон хугацаанд нь биелүүлэх боломжгүй болж төлбөр тооцоог хугацаа хэтрүүлэн гүйцэтгэх эрсдэл;
- 6.1.3 Системийн эрсдэл буюу санхүүгийн үүргээ биелүүлэх боломжгүй болсноор бусад оролцогчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг алдагдуулж, улмаар санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл;
- 6.1.4 Хууль, эрх зүйн эрсдэл буюу холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүй, дотоод журамдаа тусгаагүй зөрчил, дутагдал гаргасны улмаас банкны үйлчилгээний ашиг, орлого буурч санхүүгийн алдагдал хүлээх, байгуулсан гэрээ хэлэлцээрийг зөрчсөнөөс үүсэх эрсдэл;
- 6.1.5 Үйл ажиллагааны эрсдэл буюу цахим халдлага, хүний үйл ажиллагаа болон давагдашгүй хүчин зүйл (байгалийн гамшиг, олон нийтийн ажил хаялт, нийтийг хамарсан үймээн, зэвсэгт халдлага гэх мэт)-ээс шалтгаалан системд боловсруулалтын алдаа, саатал, тасралт гарах, цахим мэдээг боловсруулах, дамжуулах боломжгүй болох эрсдэл;
- 6.1.6 Бизнесийн эрсдэл буюу бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтээс төлбөрийн чадвар буурах, бизнесийн нэр хүнд унах эрсдэл;
- 6.1.7 Техник технологи, програм хангамжийн эрсдэл буюу хөдөлгөөнт банкны үйлчилгээний техник технологи, тоног төхөөрөмж, програм хангамж, сүлжээний холболт зэргээс үүдэн бий болох хэвийн бус ажиллагаа, саатал, тасралтаас үүсэх эрсдэл;
- 6.1.8 Залилан мэхлэх эрсдэл буюу хэрэглэгчийн зүгээс аюулгүй ажиллагаа, хөдөлгөөнт банкны үйлчилгээний зохистой ашиглалтын талаарх мэдлэг дутмагийн улмаас цахим шуудан, гар утас зэрэг сувгаар өөрийн нэвтрэх эрх болон бусад нууц мэдээллээ алдаж, хөрөнгөө бусдад ашиглуулах боломжийг бий болгосноос үүсэх эрсдэл;
- 6.1.9 Харилцаа холбооны технологийн эрсдэл буюу мэдээлэл дамжуулахад тавигдах нууцлал, аюулгүй байдлын шаардлагыг хангаагүйн улмаас үүсэх эрсдэл;
- 6.1.10 Гэрээт төлөөлөгчтэй холбоотой эрсдэл буюу гэрээт төлөөлөгч нь үйлчилгээ үзүүлэгч банкнаас тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас санаатай, санамсаргүйгээр хэрэглэгч болон банкинд хохирол учруулах эрсдэл.

6.2 Үйлчилгээ үзүүлэгч банк нь энэхүү журмын 6.1-д заасан эрсдэлийг удирдах журамтай байна.

ДОЛОО.НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

7.1 Оролцогч нь хөдөлгөөнт банкны үйлчилгээний нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

7.2 Оролцогч нь дараах шаардлагыг тусгасан нууцлал, аюулгүй байдлын журамтай байна:

- 7.2.1 Хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах;
- 7.2.2 Хөдөлгөөнт банкны үйлчилгээний техник тоног төхөөрөмж, програм хангамжийн аюулгүй ажиллагааг хангах;
- 7.2.3 Хөдөлгөөнт банкны үйлчилгээний техник тоног төхөөрөмж, програм хангамжийг учирч болзошгүй гадаад, дотоод халдлагаас хамгаалах.

7.3 Оролцогч нь илгээсэн болон хүлээн авсан гүйлгээ бүрийн логийг холбогдох хууль, журмын дагуу хадгална.

7.4 Үйлчилгээ үзүүлэгч банк нь өөрийн гэрээт төлөөлөгч, гэрээт хамтрагчийн техник технологи, програм хангамжийн нууцлал, аюулгүй байдлыг хариуцна.

7.5 Оролцогч нь цахим мэдээ илгээхдээ дараах нууцлалын шаардлагыг хангана:

- 7.5.1 Мэдээллийг нууцлах, зөвшөөрөлгүй этгээд унших боломжгүй байлгах¹;
- 7.5.2 Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах²;
- 7.5.3 Мэдээллийн эх сурвалжийн үнэн зөвийг батлах³;
- 7.5.4 Мэдээлэл хүлээн авагчийн үнэн зөвийг батлах⁴.

НАЙМ.НАЙДВАРТАЙ, ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА

8.1 Оролцогч нь хөдөлгөөнт банкны үйлчилгээний найдвартай, тасралтгүй ажиллагааг хангана.

8.2 Оролцогч нь дараах шаардлагыг тусгасан найдвартай, тасралтгүй ажиллагааны журамтай байна:

- 8.2.1 Найдвартай, тасралтгүй ажиллагаа;
- 8.2.2 Онцгой байдлын төлөвлөгөө;
- 8.2.3 Нөөц төвийн техникийн зохистой үзүүлэлт;
- 8.2.4 Гэнэтийн саатал, төлөвлөгөөт тасралтын талаар хэрэглэгч, гэрээт хамтрагч, гэрээт төлөөлөгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд мэдэгдэх.

8.3 Оролцогч нь үндсэн болон нөөц төвтэй байна:

- 8.3.1 Үндсэн төв - хөдөлгөөнт банкны үйлчилгээнд ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмж, програм хангамж, өгөгдлийн сан, сүлжээ;
- 8.3.2 Нөөц төв - үндсэн төвд гэнэтийн саатал гарсан эсхүл төлөвлөгөөт тасралтын үед орлон ажиллах техник, тоног төхөөрөмж, програм хангамж, өгөгдлийн сан, сүлжээ.

8.4 Оролцогч нь нөөц төвийн найдвартай, тасралтгүй ажиллагаанд жилд хоёроос доошгүй удаа туршилт хийж, тайлан гаргана.

8.5 Оролцогч нь гэнэтийн саатал гарч онцгой байдал үүссэн тохиолдолд үйл ажиллагааг 1 /нэг/ цагийн дотор нөөц төв рүү шилжүүлэн хэвийн үргэлжлүүлэх бөгөөд тухай бүрт Монголбанкинд мэдэгдэнэ.

8.6 Үйлчилгээ үзүүлэгч банк нь өөрийн гэрээт хамтрагч, гэрээт төлөөлөгчийн техник технологи, програм хангамжийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хариуцна.

ЕС.БАНК ХООРОНДЫН ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ

9.1 Үйлчилгээ үзүүлэгч банк нь гүйлгээг хандалтын төрлөөр нь мобайл болон интернэт гэж ангилна.

¹ Confidentiality

² Integrity

³ Non-repudiation

⁴ Authentication

9.2 Үйлчилгээ үзүүлэгч банктай гэрээ байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй гэрээт хамтрагч, гэрээт төлөөлөгчийн хөдөлгөөнт банкны үйлчилгээгээр дамжуулж буй төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэнэ.

9.3 Хүлээн авагчийн нэр, дансыг баталгаажуулсан тохиолдолд гүйлгээ илгээгч нь хэрэглэгчийн данснаас хасалтыг хийнэ.

9.4 Монголбанк нь банк хоорондын хөдөлгөөнт банкны үйлчилгээгээр дамжуулж буй төлбөр тооцоог боловсруулж, дамжуулсны шимтгэлийг “Монголбанкны үйлчилгээний хөлс шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу тооцож, тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас суутган авна.

АРВ.ХЯНАЛТ

10.1 Оролцогч, гэрээт төлөөлөгч, гэрээт хамтрагч, хэрэглэгч нь хөдөлгөөнт банкны үйлчилгээтэй холбогдох санал, гомдлоо Монголбанкинд гаргаж болно.

10.2 Монголбанк нь хөдөлгөөнт банкны үйлчилгээнд хяналт шалгалт хийх харилцаанд Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороог оролцуулж болно.

10.3 Оролцогч нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, хөдөлгөөнт банкны үйлчилгээний эрсдэлд хяналт тавина.

АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

11.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Монголбанкны хянан шалгагч Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 44.1, 44.2 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэнэ.

11.2 Монголбанк дараах нөхцөл үүссэн тохиолдолд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 44.1.5 дахь заалтад заасны дагуу хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн хязгаарлах арга хэмжээ авч болно:

11.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгч, гэрээт хамтрагч, гэрээт төлөөлөгчийн төлбөр тооцоог удаа дараа гүйцэтгээгүй, саатуулсан;

11.2.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Монголбанкнаас тавьсан найдвартай, тасралтгүй ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй.

11.3 Хөдөлгөөнт банкны үйлчилгээний нэвтрэх эрхийг нууцалж чадаагүй, нууцлал аюулгүй байдлыг хангаагүйн улмаас хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд дараах хариуцлагыг хүлээлгэнэ.

11.3.1 Үйлчилгээ үзүүлэгч банк нь хэрэглэгчийн буруутайг нотолсон бөгөөд үүнийг хэрэглэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд учирсан хохирлыг хэрэглэгч хүлээнэ.

11.3.2 Хэрэглэгчийн буруутайг нотолж чадаагүй эсхүл хэрэглэгч нотолгоог хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч банк учирсан хохирлыг хариуцан барагдуулна.

_____ оОо _____

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Гүйлгээний төрөл	Үйл ажиллагааны төрөл	Үйлчилгээний төрөл
1. Санхүүгийн гүйлгээ	1.1. Мөнгөн хадгаламж	Хугацаагүй, хугацаатай хадгаламж хийх
	1.2. Зээл	Зээл авах, эргэн төлөлт хийх, хүү төлөх
	1.3. Төлбөр тооцооны үйлчилгээ	Өөрийн данс хооронд гүйлгээ хийх Тухайн банкны данс хооронд гүйлгээ хийх Банк хоорондын гүйлгээ хийх Төлбөр гүйцэтгэх (биллинг) Гэрээт төлөөлөгчөөс бэлэн мөнгө авах Гуйвуулга хийх
	1.4. Гадаад валют худалдах, худалдан авах	Гадаад валют бэлэн бусаар худалдах Гадаад валют бэлэн бусаар худалдан авах
	1.5. Гадаад төлбөр тооцоо хийх	Гадаад шилжүүлэг хийх Гадаад гуйвуулга хийх
2. Санхүүгийн бус гүйлгээ	2.1. Мөнгөн хадгаламж	Хадгаламжийн данс нээх хүсэлт гаргах Хадгаламжийн гэрээний хугацаа сунгах
	2.2. Зээл	Зээл авах хүсэлт гаргах Зээлийн төлбөрийн хуваарь харах
	2.3. Төлбөр тооцооны үйлчилгээ	Дансаа хянах Дансны үлдэгдэл шалгах Дансны хуулга авах Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл авах Нууц үг солих Салбарын байршил, ажиллах цагийн хуваарь харах Үйлчилгээний хүү, шимтгэлийн талаар мэдээлэл авах
	2.4. Гадаад валют худалдах, худалдан авах	Гадаад валютын ханшийн мэдээлэл авах
	2.5. Гадаад төлбөр тооцоо хийх	Үйлчилгээний хүү шимтгэлийн талаар мэдээлэл авах

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

_____ БАНК

20__ оны __ улирал
(тайлант хугацаагаар)

Үйл ажиллагааны төрөл		Үйлчилгээний төрөл ⁵	Үйлчилгээний зориулалт, тайлбар
1. Санхүүгийн гүйлгээ	1.1. Мөнгөн хадгаламж		
	1.2. Зээл		
	1.3. Төлбөр тооцооны үйлчилгээ		
	1.4. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах		
	1.5. Гадаад төлбөр тооцоо хийх		
	1.6. Бусад		
	2. Санхүүгийн бус гүйлгээ	2.1. Мөнгөн хадгаламж	
2.2. Зээл			
2.3. Төлбөр тооцооны үйлчилгээ			
2.4. Гадаад валютын худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах			
2.5. Гадаад төлбөр тооцоо хийх			
2.6 Бусад			

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ (Овог нэр, гарын үсэг, тэмдэг)

(Утасны дугаар, цахим хаяг)

20__ оны __ сарын __ - ны өдөр

⁵ Хавсралт 1-д заасан хөдөлгөөнт банкны үйлчилгээний төрлөөр;

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАНКНЫ САНХҮҮГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
_____ **БАНК**

20__ оны __ улирал
(тайлант хугацаагаар)

№	Үйл ажиллагааны төрөл	Үйлчилгээний төрөл ⁶	Мобайл хандалт			Интернэт хандалт		
			валют	тоо	дүн	валют	тоо	дүн
1	Мөнгөн хадгаламж	1.1	MNT			MNT		
			USD			USD		
			EUR			EUR		
			CNY			CNY		
			YEN			YEN		
				
		1.2					
		1.3					
2	Зээл	2.1	MNT			MNT		
			USD			USD		
			EUR			EUR		
			CNY			CNY		
			YEN			YEN		
				
		2.2					
		2.3					
3	Төлбөр тооцооны үйлчилгээ	3.1	MNT			MNT		
			USD			USD		
			EUR			EUR		
			CNY			CNY		
			YEN			YEN		
				
		3.2					
		3.3					
4	Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах	4.1	MNT			MNT		
			USD			USD		
			EUR			EUR		
			CNY			CNY		
			YEN			YEN		

⁶ Хавсралт 3-т тодорхойлсон үйлчилгээний төрлөөр;

				
		4.2		
		4.3		
5	Гадаад төлбөр тооцоо	5.1	MNT			MNT		
			USD			USD		
			EUR			EUR		
			CNY			CNY		
			YEN			YEN		
				
		5.2		
5.3				
НИЙТ:			MNT			MNT		
НИЙТ:			USD			USD		
НИЙТ:			EUR			EUR		
НИЙТ:			CNY			CNY		
НИЙТ:			YEN			YEN		
НИЙТ:				

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ (Овог нэр, гарын үсэг, тэмдэг)

(Утасны дугаар, цахим хаяг)

20__ оны __ сарын __ - ны өдөр

БАНК ХООРОНДЫН ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮГИЙН
ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

_____ БАНК⁷

20__ оны __ улирал
(төгрөгөөр, тайлант хугацаагаар)

№	Үйл ажиллагааны төрөл	Үйлчилгээний төрөл ⁸	Мобайл хандалтаар хийгдсэн гүйлгээ		Интернэт хандалтаар хийгдсэн гүйлгээ	
			тоо	дүн	тоо	дүн
1	Мөнгөн хадгаламж	1.1				
		...				
2	Зээл	2.1				
		...				
3	Төлбөр тооцооны үйлчилгээ	3.1				
		...				
НИЙТ: МӨНГӨН ХАДГАЛАМЖ						
НИЙТ: ЗЭЭЛ						
НИЙТ: ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ						

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ (Овог нэр, гарын үсэг, тэмдэг)

(Утасны дугаар, цахим хаяг)

20__ оны __ сарын __ - ны өдөр

⁷ Үйлчилгээ үзүүлэгч банк нь зөвхөн өөрийн илгээсэн гүйлгээний талаарх мэдээллийг ирүүлнэ.

⁸ Хавсралт 3-т тодорхойлсон үйлчилгээний төрлөөр;

“Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам”-ын
6 дугаар хавсралт

ЗАЛИЛАН МЭХЛЭХ БОЛОН ХУЛГАЙН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
_____ БАНК

20__ оны __ улирал
(тайлант хугацаагаар)

№	Залилан мэхлэх, хулгайн арга	Мобайл хандалт			Интернэт хандалт			Шийдвэрлэгдсэн гүйлгээ		Шийдвэрлэгдээгүй гүйлгээний тоо
		валют ⁹	тоо	дүн	валюг	тоо	дүн	арга/хэрхэн	тоо	
1										
2										
3										
...										
НИЙТ:										

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ (Овог нэр, гарын үсэг, тэмдэг)

(Утасны дугаар, цахим хаяг)

20__ оны __ сарын __ - ны өдөр

⁹ Хавсралт 4-т заасан валютын төрлөөр ангилна.

ГЭРЭЭТ ТӨЛӨӨЛӨГЧ, ГЭРЭЭТ ХАМТРАГЧИЙН ТАЙЛАН

_____ БАНК

20__ оны __ улирал
(аймгаар, өссөн тоогоор)

№	Хот, аймаг	Гэрээт хамтрагчийн тоо	Гэрээт төлөөлөгчийн тоо
1	Архангай		
2	Баянхонгор		
3	Булган		
4	Говь-Алтай		
5	Говьсүмбэр		
6	Дорнод		
7	Дорноговь		
8	Дундговь		
9	Завхан		
10	Өвөрхангай		
11	Өмнөговь		
12	Сүхбаатар		
13	Сэлэнгэ		
14	Төв		
15	Увс		
16	Ховд		
17	Хөвсгөл		
18	Хэнтий		
Нийт (дээрх аймгууд)			-
19	Дархан-Уул		
20	Орхон		
21	Улаанбаатар		
Нийт (дээрх хотууд)			-
Нийт (Улс)			-

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ (Овог нэр, гарын үсэг, тэмдэг)

(Утасны дугаар, цахим хаяг)

20__ оны __ сарын __ - ны өдөр

